**Method:** *M. tuberculosis* isolates were originally detected in 2023 from 90 different tuberculosis patients in the NCCD, Mongolia. The drug susceptibility testing was performed using MGIT 960/TB eXiST (BD, Franklin Lakes, NJ, USA). The critical concentrations of BDQ, DLM, LZD, and MFX were 1.0, 0.06, 1.0, and 0.25 µg/mL, respectively (according to WHO standard 2018). The drug-containing medium was prepared *in-house* in the NCCD TB laboratory. *M. tuberculosis* H37Rv was used as internal quality control.

**Results:** Of all cases, 60% (54/90) were collected from new cases, 16.7% (15/90) were previously treated TB cases, and 23.3% (21/90) were follow-up cases of DR treatment. Out of the total 90 isolate cultures, 98.9% (89/90) were RR/MDR. Based on the definitions, 51 (56.7%) were RR and 38 (42.2%) were MDR.



According to the results of resistance to the new drugs, 86.6% (78/90) were susceptible to all 4 drugs and 13.3% (12/90) were resistant. Of the resistant cases, 8.9% (8/12) were resistant to MFX and 4.4% (4/12) were resistant to MFX and DLM.

Of the 12 MFX-resistant isolate cultures, 100% were found to be resistant to the Fluoroquinolones by Genotype MTBDRs/ assay. Of these MFX and DLM-resistant cases, 7 (58.3%) were identified in samples of diagnosis and 5 (41.7%) were follow-up samples.

**Conclusion:** The introduction of novel drugs into treatment must be accompanied by continuous phenotypic susceptibility testing including minimum inhibitory concentration. The analysis of genetic determinants of resistance may show limitations in new drugs.

**Keywords:** Mycobacterium tuberculosis, drug-resistant, novel anti-tuberculosis drugs

## **MGIT 960/ TB eXiST АШИГЛАН СҮРЬЕЭГИЙН ЭСРЭГ ШИНЭ ЭМЭНД ТЭСВЭРЖИЛТ ТОДОРХОЙЛСОН ҮР ДҮН**

Э.Баасансүрэн<sup>1</sup>, Г.Оюунчимэг<sup>1</sup>, Б.Баясгалан<sup>1</sup>, Т.Оюунтуяа<sup>1</sup>, Б.Цэцэгтуяа<sup>1</sup>,  
Б.Буянхишиг<sup>1</sup>, Ж.Байгалмаа<sup>1</sup>, Д.Баярболд<sup>2</sup>, С.Митарай<sup>3</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

<sup>2</sup> Эрүүл Мэндийн Яам

<sup>3</sup> Япон улсын сүрьеэгийн эрдэм шинжилгээний хүрээлэн

E-mail: [baasansuren0624@gmail.com](mailto:baasansuren0624@gmail.com)

Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тархалт дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар байна. Сүүлийн жилүүдэд олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС)-ийн эмчилгээнд бедакулин (BDQ), деламамид (DLM) зэрэг шинэ эмүүдийг хэрэглэхийг зөвлөмж болгосон. Эдгээр эмүүдийг Монгол улс 2017 оноос ОЭТС-ийн эмчилгээний горимд хэрэглэж эхэлсэн. Бид ОЭТС-ийн ялгасан өсгөвөрт BDQ, DLM, линезолид (LZD), моксифлоксацин (MFX)-ы тэсвэржилтийг MGIT 960/ TB eXiST программыг ашиглан тодорхойлохыг зорилоо.

**Арга, аргачлал:** Эргэмж судалгааны загвараар 2023 онд Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (ХӨСҮТ)-ийн Сүрьеэгийн лавлах лаборатори (СЛЛ)-д ялгасан 90 өсгөвөрт шинэ эмэнд тэсвэржилт тодорхойлсон. Эдгээр ялгасан өсгөвөр дундаас шинэ эмэнд тэсвэржилт илэрсэн тохиолдлыг хамгийн багадаа хоёр удаа шинжилгээг давтаж баталгаажуулсан. Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээг MGIT 960/TB eXiST (BD, Franklin Lakes, NJ, USA) ашиглан хийсэн. BDQ, DLM, LZD болон MFX-ийн концентраци нь 1.0, 0.06, 1.0 ба 0.25 мкг/мл (ДЭМБ-ын 2018 оны стандартын дагуу) байв. Дээрх стандартад үндэслэн СЛЛ-д ажлын уусмалыг бэлтгэсэн. *M.tuberculosis*-ын H37Rv стандарт омгийг дотоод чанарын хяналт болгон ашигласан.

**Үр дүн:** Нийт тохиолдлын 60% (54/90) нь оношилгооны шинэ тохиолдол, 16.7% (15/90) нь урьд сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байсан тохиолдол, 23.3% (21/90) нь ЭТС-ийн эмчилгээний хяналтын тохиолдол байсан. Нийт ялгасан

өсгөврийн 98.9% (89/90) нь Риф/ОЭТС байсан. Эмэнд тэсвэржилтээр авч үзвэл РТС 56.7% (51/90), ОЭТС 42.2% (38/90) байна. Шинэ эмэнд тэсвэржилтийн үр дүнгээр 86.7% (78/90) нь бүх эмүүдэд мэдрэг, 13.3% (12/90) нь эмэнд тэсвэртэй үр дүн гарсан. Эмэнд тэсвэртэй тохиолдлын 8.9% (8/12) MFX дангаараа тэсвэртэй бол 4.4% (4/12) нь MFX болон DLM тэсвэртэй үр дүн гарсан. Эдгээр MFX тэсвэртэй 12 тохиолдлын тухайн сорьцонд MTBDRs/ шинжилгээ хийгдсэн ба 100% фторхинолины бүлэгт тэсвэртэй дүгнэгдсэн. Тэсвэртэй 12 тохиолдлын 7 (58.3%) нь оношилгооны сорьцонд тодорхойлогдсон байна. Харин 5 (41.7%) тохиолдолд эмчилгээ хяналтын сорьцонд тэсвэржилт тодорхойлогдсон.

**Дүгнэлт:** ЭТС-ийн эмчилгээнд хэрэглэж буй шинэ эмүүдийн тэсвэржилтийг фенотипын аргаар тэр дундаа хамгийн бага дарангуйлах концентраци аргаар тодорхойлох тасралтгүй хэрэгцээ байна. Бидний хувьд эдгээр шинэ эмүүдийн тэсвэржилтийг нэмэлтээр генотипын шинжилгээнд хамруулаагүй нь хязгаарлагдмал тал байлаа.

**Түлхүүр үгс:** Сүрьеэгийн микобактер, эмэнд тэсвэртэй сүрьеэ, сүрьеэгийн эсрэг шинэ эм

## **CAPSULE CURRICULUM VITAE**

**NAME:** ERDENEGEREL NARMANDAKH

**CURRENT AFFILIATION AND APPOINTMENT:**

- ✓ National Tuberculosis Reference Laboratory,
- ✓ National Center for Communicable Diseases,  
Mongolia
- ✓ Laboratory doctor

**E-mail:** [eejiinar@gmail.com](mailto:eejiinar@gmail.com)



**DEGREE:** Master of Science in Medical Science

**EMPLOYMENT:**

FROM:2009 TO: until now

EMPLOYER: National Center for Communicable Diseases

POSITION HELD: Laboratory doctor

**INTERESTED RESEARCH ARE:**

Tuberculosis, mycobacteriology, molecular biology

## **PRELIMINARY RESULTS OF A COMPARATIVE STUDY OF PERFORMANCE ON QIAREACH QUANTIFERON-TB AND QUANTIFERON-TB GOLD PLUS TEST FOR DIAGNOSIS OF TUBERCULOSIS INFECTION IN MONGOLIA**

Erdenegerel Narmandakh<sup>1</sup>, Enkhtsetseg Tumor<sup>1</sup>, Oyuntuya Tumenbayar<sup>1</sup>, Gundsuren Sharkhuu<sup>1</sup>, Baasansuren Erkhembayar<sup>1</sup>, Solongo Bat<sup>2</sup>, Adiya Damdindorj<sup>3</sup>, Naranzul Dambaa<sup>1</sup>, Bilegtsaikhan Tsolmon<sup>4</sup>, Sarantuya Jav<sup>4</sup>, Buyankhishig Burneebaatar<sup>1</sup>, Satoshi Mitarai<sup>5</sup>

<sup>1</sup>National Center for Communicable Diseases, Mongolia

<sup>2</sup>National Center for Transfusion Medicine of Mongolia

<sup>3</sup>Bayanzurkh District Health Center, Mongolia

<sup>4</sup>Mongolian National University of Medical Science

<sup>5</sup>Research Institute of Tuberculosis, Japan Anti-Tuberculosis Association, Japan

E-mail: [eejiinar@gmail.com](mailto:eejiinar@gmail.com)

**Background.** About a quarter of the global population is estimated to have been infected with tuberculosis (TB) bacteria. There is a 5–10% lifetime risk of developing tuberculosis in those who are infected with TB bacteria. Therefore, controlling tuberculosis infection is essential to the global End TB Strategy. Currently, the two test families used to diagnose tuberculosis infection are interferon- $\gamma$  release assays (IGRA) and tuberculin skin tests (TST). IGRA tests have advantages over TST, but ELISA based QuantiFERON-TB Gold Plus assay (QFT-Plus) requires highly qualified laboratory personnel and sophisticated laboratories to run ELISA. One of the new IGRA tests, QIAreach QuantiFERON-TB assay (QIAreach), requires only one ml of blood from the patient and is portable and simple to use. Our study aimed to evaluate the diagnostic performance and accuracy of the novel QIAreach assay to the ELISA-based conventional QFT-Plus assay.

**Methods.** In a cross-sectional study, whole blood samples were collected from three groups: bacteriologically confirmed active TB patients, TB contacts, and healthy volunteers (blood donors) at the TB clinic of the National Center for Communicable Diseases, 6 TB dispensaries at the District Health Center of Ulaanbaatar city and National Center for Transfusion Medicine using a lithium heparin tube. Blood samples were transported to the National Tuberculosis Reference Laboratory of NCCD for QIArearch and QFT-Plus processing, testing, and interpretation in accordance with the manufacturer's instructions. The sensitivity, specificity, and agreement of the QIArearch assay were determined using QFT-Plus as the reference standard.

**Results.** We recruited 416 participants which are 196 healthy volunteers, 162 TB contacts, and 58 pulmonary TB patients. Of these, 54.5% (227/416) were females with a median age of 28 years (interquartile range: 21, 49). Of this, 154 participants had paired results, of whom 86 donors, 50 TB contacts, and 18 TB patients. In the remaining 262 cases, QIArearch or ELISA-based QFT was performed alone. Among participants with paired results, 57.8% (89/154) were positive and 26.0% (40/154) negative on both assays, while 16.2% (25/154) had discordant results. Sensitivity of QIArearch was 97.6% (95% CI: 87.4%–99.9%), 100% (95% CI: 89.4%–100%) and 100% (95% CI: 78.2%–100%) and specificity was 65.6% (95% CI: 52.3%–77.3%), 81.3% (95% CI: 54.4%–96.0%) and 100% (95% CI: 29.2%–100%) in the healthy volunteers, TB contacts and pulmonary TB patients, respectively. Also, the Kappa coefficient was 0.49, 0.86, and 1.0, respectively.

**Conclusion.** The sensitivity of the QIArearch was 100% in TB patients but the specificity was 65.6% in the healthy group. In addition, QIArearch revealed excellent agreement in both TB contacts and TB patients, but modest agreement in the healthy group. The results could have been impacted by the comparison analysis's limited sample size and the lack of a gold standard for tuberculosis infection. As well as more evidence for this novel IGRA assay for TB infection remains needed in low-resource, TB high-burden settings.

**Keywords:** QIArearch QuantiFERON-TB, QuantiFERON-TB Gold Plus, tuberculosis infection



**СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАРЫГ ОНОШЛОХ QIAREACH QUANTIFERON-TB  
БОЛОН QUANTIFERON-TB GOLD PLUS ШИНЖИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ  
ХАРЬЦУУЛСАН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН, МОНГОЛ УЛС**

Н.Эрдэнэгэрэл<sup>1</sup>, Т.Энхцэцэг<sup>1</sup>, Т.Оюунтуяа<sup>1</sup>, Ш.Гүндсүрэн<sup>1</sup>, Э.Баасансүрэн<sup>1</sup>,  
Б.Солонго<sup>2</sup>, Д.Адъяа<sup>3</sup>, Д.Наранзул<sup>1</sup>, Ц.Билэгтсайхан<sup>4</sup>, Ж.Сарантуяа<sup>4</sup>,  
Б.Буянхишиг<sup>1</sup>, С.Митарай<sup>5</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний төв

<sup>2</sup>Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв

<sup>3</sup>Баянзүрх дүүргийн Эрүүл Мэндийн Төв

<sup>4</sup>Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

<sup>5</sup>Япон улсын Сүрьеэтэй Тэмцэх Нийгэмлэг, Сүрьеэгийн Эрдэм Шинжилгээний  
Хүрээлэн

E-mail: [eegiinar@gmail.com](mailto:eegiinar@gmail.com)

**Үндэслэл:** Дэлхийн хүн амын дөрөвний нэг орчим нь сүрьеэгийн нянгаар халдварласан гэсэн тооцоо байна. Тэдний 5-15% нь амьдралынхаа аль нэг үе шатанд идэвхтэй хэлбэрийн сүрьеэд шилждэг байна. Иймээс сүрьеэгийн халдварыг хянах нь дэлхийн Сүрьеэтэй Тэмцэх Стратегийн асуудалд чухал ач холбогдолтой юм. Одоогийн байдлаар сүрьеэгийн халдварыг оношлоход туберкулины арьсны сорил (TST), интерферон-γ ялгаруулах шинжилгээ (IGRA)-г өргөн ашиглаж байна. IGRA шинжилгээ нь TST-ээс давуу талтай боловч ELISA-д суурилсан QuantiFERON-TB Gold Plus шинжилгээ (QFT-Plus)-г гүйцэтгэхийн тулд мэргэшсэн лабораторийн мэргэжилтэн, өндөр түвшний лабораторийн нөхцөл шаарддаг. IGRA-ийн шинэ шинжилгээний аргын нэг болох QIArearch QuantiFERON-TB нь өвчтөнөөс ердөө нэг мл цус шаарддаг бөгөөд зөөврийн, хэрэглэхэд хялбар арга юм. Бидний судалгаа нь шинээр нэвтэрч буй QIArearch шинжилгээг ELISA-д суурилсан уламжлалт QFT-Plus шинжилгээтэй харьцуулан оношилгооны гүйцэтгэл, тохироог үнэлэх зорилготой юм.



**Арга аргачлал:** Энэхүү судалгааг агшингийн загвараар хийж гүйцэтгэсэн. Уг судалгаанд нян судлалаар батлагдсан сүрьеэтэй өвчтөн, сүрьеэгийн хавьтал болон эрүүл бүлгийн сайн дурын ажилтан (цусны донор) гэсэн 3 бүлэг оролцогчдыг Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвийн сүрьеэгийн клиник, 6 Дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн сүрьеэгийн диспансер, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвийг түшиглэн хамруулсан. Судалгаанд оролцогчдоос бүхэл цусыг лити- гепаринтай хуруу шил ашиглан цуглуулж, цусны сорьцыг ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн Үндэсний Лавлах Лабораторид тээвэрлэн, үйлдвэрлэгчийн зааврын дагуу QIAreacH болон QFT-Plus-ийн шинжилгээг гүйцэтгэсэн. QIAreacH шинжилгээний мэдрэг, өвөрмөц чанар, нарийвчлалын тохироог QFT-Plus аргыг жишиг стандарт болгон тодорхойлсон.

**Үр дүн:** Бид 196 эрүүл сайн дурын ажилтан, 162 сүрьеэгийн хавьтал, 58 уушгины сүрьеэтэй өвчтөн гэсэн 416 оролцогч хамруулсан. Тэдний 54.5% (227/416) нь эмэгтэйчүүд, дундаж нас 28 (квартал хоорондын хүрээ:21, 49) байв. Үүнээс 154 оролцогч шинжилгээний аргыг харьцуулах боломжтой байсан ба 86 донор, 50 сүрьеэгийн хавьтал, 18 сүрьеэтэй өвчтөн байна. Үлдсэн 262 тохиолдолд QIAreacH эсвэл ELISA-д суурилсан QFT-г дангаар нь хийсэн. Хосолсон үр дүнтэй оролцогчдын 57.8% (89/154) нь эерэг, 26.0% (40/154) сөрөг үр дүнтэй байсан бол 16.2% (25/154) нь зөрүүтэй үр дүнтэй байсан. QIAreacH-ийн мэдрэг чанар 97.6% (95% CI: 87.4%–99.9%), 100% (95% CI: 89.4%–100%) ба 100% (95% CI: 78.2%–100%), өвөрмөц чанар 65.6% (95% CI: 52.3%–77.3%), 81.3% (95% CI: 54.4%–96.0%), 100% (95% CI: 29.2%–100%), эрүүл сайн дурынхан, сүрьеэтэй хавьтал, уушгины сүрьеэтэй өвчтөнд тус тус үзүүлэлтэй байлаа. Мөн Каппа коэффициент 0.49, 0.86 ба 1.0 тус тус байв.  $P < 0.001$  статистик ач холбогдол бүхий үр дүн гарсан.

**Дүгнэлт:** QIAreacH аргын мэдрэг чанар нь сүрьеэтэй өвчтөний бүлэгт 100% байсан боловч эрүүл бүлэгт өвөрмөц чанар нь 65.6% байв. Мөн QIAreacH нь сүрьеэгийн болон сүрьеэтэй өвчтөний бүлэгт шинжилгээний тохирооны түвшин өндөр байсан боловч эрүүл бүлэгт дунд тохироотой байна. Харьцуулах шинжилгээний түүврийн хэмжээ хязгаарлагдмал, сүрьеэгийн халдварын алтан стандарт байхгүй зэрэг нь үр дүнд нөлөөлсөн байж болох юм. Сүрьеэгийн тархалт, өвчлөл ихтэй, хөгжиж байгаа оронд сүрьеэгийн

халдварын талаарх энэхүү шинэ IGRA шинжилгээний нэмэлт нотолгоо шаардлагатай хэвээр байна.


**Түлхүүр үг:** QIAreach QuantiFERON-TB, QuantiFERON-TB Gold Plus, сүрьеэгийн халдвар

## **CAPSULE CURRICULUM VITAE**

**NAME:** TSERENNADMID NYAMSAIKHAN

**CURRENT AFFILIATION AND APPOINTMENT:**

**E-mail:** tsekunyam@gmail.com



**DEGREE**

- ✓ Biomedical engineer Bachelor's Degree,  
Mongolian National Medical University
- ✓ Medical cytologist,  
Mongolian National University of Medical Sciences

**EMPLOYMENT:**

**FROM:** 2020 **TO:** until now

**EMPLOYER:** TB Surveillance and Research Department, National Center for Communicable Diseases

**POSITION HELD:** Biomedical Researcher in the Tuberculosis Reference Laboratory

**INTERESTED RESEARCH ARE:**

**A LAMP PILOT STUDY INVOLVING ISOLATED STRAINS OF THE  
*MYCOBACTERIUM TUBERCULOSIS*  
COMPLEX, INCLUDING *MYCOBACTERIUM BOVIS***

Tserennadmid Nyamsaikhan<sup>1</sup>, Ochirdari Battsengel<sup>1</sup>, Enkhbolor Davaakhuu<sup>1</sup>,  
Tsetsegtuya Borolzoi<sup>1</sup>, Oyunchimeg Erdene<sup>1</sup>, Baigalmaa Jantsansengee<sup>1</sup>,  
Buyankhishig Burneebaatar<sup>1</sup>, Bayarbold Dangaa<sup>2</sup>,  
Mitsuru Nakase<sup>3</sup> and Takashi Kimura<sup>3</sup>

<sup>1</sup>National center for communicable diseases

<sup>2</sup>Health Department, Ministry of Health

<sup>3</sup>Laboratory of Comparative Pathology, Faculty of Veterinary Medicine, Hokkaido  
University

E-mail: [tsekunyam@gmail.com](mailto:tsekunyam@gmail.com)

**Background:** *Mycobacterium tuberculosis* is the primary cause of human tuberculosis (TB) although there is evidence that humans may underestimate the burden of tuberculosis caused by *M. bovis*, and it is estimated that about one-third of all TB cases are caused by *M. bovis*. In low-income and high prevalence of TB countries *M. bovis* surveillance systems and laboratory methods are commonly used to diagnose human TB. They cannot differentiate *M. bovis*, and it has been hypothesized that all cases are attributed to *M. tuberculosis*. The purpose of the study is to use Loop-mediated isothermal amplification (LAMP) to isolate *M. bovis* and *M. tuberculosis* from clinical samples of TB patients and determine which strains are the cause of human tuberculosis.

**Material and method:** The LAMP test was performed in 49 specimens from new diagnostic cases including 16 in clinical samples and 33 isolations in solid LJ culture with pyruvate in NTRL, NCCD In this study, we used the LAMP test kits for *M. tuberculosis* and for *M. bovis*, which were made at Hokkaido University International Institute for Zoonosis Control, for the analysis of clinical samples. LAMP assay used by the Genoese kit (Hain Lifescience, Nehren, Germany) for

DNA extraction and Genotype MTBC by standard method for identification of *M. tuberculosis* and *M. bovis* of the *Mycobacterium tuberculosis* complex.

**Result:** This study covered cases which are 34.6% (n=17) females and 65.4% (n=32) men. The average age was 41.8 ( $\pm 15.2$ ). Type of samples: 89.8% (n=44) Pulmonary, 10.2% (n=5) non-pulmonary. Geographic location is 59.2% (n=29) in urban and 40.8% (n=20) in rural. All strains were *M. tuberculosis*. Among 49 clinical samples, 33 were successfully cultured on solid media (20 LJ with glycerol and MGIT but 13 LJ with pyruvate), and they were all positive for *M. tuberculosis* by *M. tuberculosis* kit of LAMP. The remaining 16 cases were investigated without culturing on a solid medium. Six of the 16 were positive and 10 were negative for Xpert MTB/RIF. Among 6 Xpert MTB/RIF-positive samples, 2 samples were positive for *M. tuberculosis* LAMP. All 49 cases were negative for *M. bovis* LAMP.

**Conclusion:** In this study, *M. bovis* was undetected. However, this study suggests that *M. tuberculosis* was dominated in isolated strains in Mongolia.

In the future, it is necessary to expand the number of samples to be included in the LAMP analysis to study its sensitivity and specificity.

**Keywords:** *M. tuberculosis*, *M. bovis*, LAMP

## ЯЛГАСАН ОМОГТ LAMP АРГААР ХИЙСЭН ТУРШИЛТЫН

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Н. Цэрэннадмид<sup>1</sup>, Б. Очирдарь<sup>1</sup>, Б. Цэцэгтуяа<sup>1</sup>, Д. Энхболор<sup>1</sup>, Э. Оюунчимэг<sup>1</sup>,  
Ж. Байгалмаа<sup>1</sup>, Б. Буянхишиг<sup>1</sup>, Д. Баярболд<sup>2</sup>, Mitsuru Nakase<sup>3</sup>, Takashi Kimura<sup>3</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв

<sup>2</sup>Эрүүл Мэндийн Яамны Нийтийн эрүүл мэндийн газар

<sup>3</sup> Хоккайдогийн их сургуулийн мал эмнэлгийн факультет

E-mail: [Tsekunyam@gmail.com](mailto:Tsekunyam@gmail.com)

**Үндэслэл:** Хүний сүрьеэгийн үндсэн шалтгаан нь *M. tuberculosis* болж байгаа хэдий ч *M. bovis*-оор үүсгэгдсэн сүрьеэгийн дарамтыг хүн төрөлхтөн дутуу үнэлж байж болох нотолгоо байгаа ба сүрьеэгийн тохиолдлыг гурав хуваасны нэг орчим хувь нь *M. bovis*-оор үүсгэгдсэн гэх тооцоолол байдаг. Сүрьеэгийн тархалт өндөртэй, бага орлоготой улс орнуудад *M. bovis*-ийн тандалтын тогтолцоогүй, хүний сүрьеэг оношлоход түгээмэл хэрэглэгддэг лабораторийн аргууд нь *M. bovis*-ийг ялгах чадваргүйгээс бүх тохиолдлыг *M. tuberculosis*-ээр үүсгэгдсэн гэж үздэг гэсэн таамаглалууд байна. Loop-mediated isothermal amplification (LAMP) шинжилгээний арга ашиглан сүрьеэтэй өвчтөний эмнэлзүйн сорьцоос ялган *Mycobacterium bovis* ба *Mycobacterium tuberculosis*-ыг ялган дүйж, хүний сүрьеэ ямар зүйлээр үүсгэгдэж байгааг тодорхойлохыг зорьсон.

**Материал арга зүй:** ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн лавлах лаборатортийг түшиглэн 2023 оны оноошилгооны шинэ тохиолдлын 49 сорьцонд (эмнэлзүйн 16 сорьц, глицерол болон пируват агуулсан Левенштэйн-Иенсэний хатуу тэжээл орчин, шингэн тэжээлт орчинд ургасан 33 омогт) LAMP шинжилгээгээ хийсэн. Ялган дүйлт хийхдээ genolyse цомог ашиглан ДНХ ялгаж, стандар арга болох Genotype MTBC (Hain Lifescience, Nehren, Germany) оношлуураар ялган дүйлт хийсэн. Мөн эмнэлзүйн сорьцонд LAMP шинжилгээний *M. tuberculosis*

болон *M. bovis* илрүүлэх цомог (Хоккайдогийн их сургуулийн мал эмнэлгийн факультетийн лабораторт үйлдвэрлэсэн)-ийг судалгаанд ашигласан.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан тохиолдлын хүн амзүйн үзүүлэлтийг эргэн судлахад 34.6% (17) нь эмэгтэй, 65.4% (32) өвчтөний дундаж нас 41.8 ( $\pm 15.3$ ) байна. Эмнэлзүйн сорьцын төрөл: 89.8% (n=44) уушгины, 10.2% (n=5) уушгины бус эрхтэний байна. Газарзүйн байршлын хувьд 59.2% (n=29) нь УБ хотын, 40.8% (n=20) нь аймаг орон нутгийн хүн ам байсан. LAMP-ын аргаар MTB болон *M. bovis* цомог ашиглан шинжилсэн оношилогооны 49 тохиолдлын 33 нь ялгасан омог, 16 нь эмнэлзүйн сорьц байсан. Хатуу, шингэн тэжээлт орчинд ургасан 33 өсгөвөрт 100% *M. tuberculosis* илэрч, эдгээрийн 13 нь зөвхөн пируват агуулсан тэжээлт орчинд ургасан өсгөвөр байв. Харин Xpert MTB/RIF шинжилгээ эерэг илэрсэн 33.3% (2/6)-д, Xpert MTB/RIF шинжилгээр илрээгүй 0% (0/10)-тай *M. tuberculosis* илэрсэн байна.

**Дүгнэлт:** Бидний судалгаагаар Монголд ялгасан омгийн дотор *M. bovis* илрээгүй ба *M. tuberculosis* давамгайлж байна. Цаашид LAMP шинжилгээнд хамруулах сорьцын тоог өргөжүүлэн мэдрэг өвөрмөц чанарыг судлах хэрэгтэй байна.

**Түлхүүр үг:** *M. tuberculosis*, *M. bovis*, LAMP, Genotype MTBC


## CAPSULE CURRICULUM VITAE

**NAME:** Enkhtuul Batchuluun

**CURRENT AFFILIATION AND APPOINTMENT:**

Institute of Veterinary Medicine

**E-mail:** aguallena@gmail.com



**DEGREE**

✓ Master

**EMPLOYMENT:**

FROM: 2009 TO: 2024

EMPLOYER: Researcher

POSITION HELD: Laboratory of Infectious disease and immunology

**INTERESTED RESEARCH ARE:**

Equine Glanders and bacterial-borne diseases



## **SERO-EPI-MEDIOLOGICAL SITUATION OF THE EQUINE GLANDERS IN MONGOLIA**

Batchuluun EHKTUUL<sup>1</sup>, Ochirbat KHURTSBAATAR<sup>1</sup>, Baasansuren LKHAM<sup>1</sup>,  
Tumurtogdikh AGIIMAA<sup>1</sup>, Burenbaatar BUYANBADRAKH<sup>1</sup>,  
Jugderkhorloo UNENBAT<sup>1</sup>, Amgalan-Enkh BINDERYA<sup>1</sup>,  
LIUSHIQI Borjigin<sup>2</sup>, Yasuhiko SUZUKI<sup>3</sup>, Takashi KIMURA<sup>4</sup> and Vanaabaatar  
BATBAATAR<sup>1</sup>.

<sup>1</sup>Infectious Diseases and Immunology, Institute of Veterinary Medicine,  
Mongolian University of Life Science, Mongolia

<sup>2</sup>Faculty of Veterinary Medicine, Okayama University of Science, Japan

<sup>3</sup>International Institute for Zoonosis Control and Faculty of Veterinary Medicine,  
Hokkaido University, Japan

<sup>4</sup>Laboratory of Comparative Pathology, Department of Clinical Sciences,  
Faculty of Veterinary Medicine, Hokkaido University, Japan

E-mail to [vanaabaatar.b@gmail.com](mailto:vanaabaatar.b@gmail.com)

Glanders is a zoonotic disease caused by the gram-negative bacterium *Burkholderia mallei*, which mainly affects horses and solid-hoofed but also affects some carnivores, and is transmitted from infected animals to humans. The disease was eradicated in the developed countries of Western Europe in the 20th century, but it has recently resurged. In Mongolia, the first surveillance conducted in 1943 and 1944 showed an infection rate of 32-36.5 percent, which then decreased to 0.05 percent in 1985 due to measures taken to control the disease. In 2011, it increased to 0.19 percent, and by 2015, it had reached 0.98 percent. From 2021 to 2023, using Random multi-stage cluster sampling (WHO 2015), we collected 2,220 blood serum samples from 256 herders in 43 sums of 12 provinces representing western, central, and eastern regions of Mongolia, and 600 samples from 47 herders in Khan-Uul, Baganuur, and Nalaikh districts of the capital, totally 2,820 horses.

The collected sera were reacted with the CFT Antigen of diagnosis for GLANDERS (Biocombinat, Ulaanbaatar, Mongolia) according to the manufacturer's instructions. The CFT of serum samples taken from 2,820 horses revealed an infection rate of 1.1% across the 12 provinces and 3 districts mentioned above. It attracts attention that 3/4 of the provinces, 2/3 of the Soums, and 8.2% of the herders have been diagnosed with equine glanders, indicating a re-emerging disease in Mongolia.

**Keywords:** *B. mallei*, CFT, Sero- surveillance

## **МОНГОЛ УЛС ДАХ АДУУНЫ ЯМ ӨВЧНИЙ ХАЛДВАРЛАЛТЫН ТҮВШИНГ ИЙЛДЭС СУДЛАЛЫН АРГААР ТАНДСАН НЬ**

Батчулууны ЭНХТУУЛ<sup>1</sup>, Очирбатын ХУРЦБААТАР<sup>1</sup>, Баасансүрэнгийн ЛХАМ<sup>1</sup>,  
Төмөртогтохын АГИЙМАА, Бүрэнбаатарын БУЯНБАДРАХ<sup>1</sup>,  
Жүгдэрхолоогийн ҮНЭНБАТ<sup>1</sup>, Амгалан-Энхийн БИНДЭРЬЯА,  
LIUSHIQI Borjigin<sup>2</sup>, Yasuhiko SUZUKI<sup>3</sup>, Takashi KIMURA<sup>4</sup>,  
Ванаабаатарын БАТБААТАР<sup>1</sup>

<sup>1</sup>Infectious Diseases and Immunology, Institute of Veterinary Medicine,  
Mongolian University of Life Science, Mongolia

<sup>2</sup>Faculty of Veterinary Medicine, Okayama University of Science, Japan

<sup>3</sup>International Institute for Zoonosis Control and Faculty of Veterinary Medicine,  
Hokkaido University, Japan

<sup>4</sup>Laboratory of Comparative Pathology, Department of Clinical Sciences,  
Faculty of Veterinary Medicine, Hokkaido University, Japan

E-mail: [vanaabaatar.b@gmail.com](mailto:vanaabaatar.b@gmail.com)

Ям нь грам сөрөг *Burkholderia mallei* нянгаар үүсгэгддэг ихэвчлэн адуу болон битүү туурайтан амьтад өвчлөхөөс гадна зарим махчин амьтад өвчилдөг, өвчтэй мал амьтнаас хүнд халдварладаг зооноз өвчин юм. Уг өвчнийг 20-р зуунд баруун европын өндөр хөгжилтэй оронуудад устгасан боловч сүүлийн үед дахин сэргэж байгаа өвчний тоонд орж байгаа юм. Монгол оронд анх 1943, 1944 онуудад хийсэн тандалтаар 32-36.5 хувийн халдварлалттай байсан бөгөөд улмаар өвчинтэй тэмцэх арга хэмжээ авснаар 1985 онд 0.05 хувь хүртэл буурсан. 2011 онд хийсэн тандах шинжилгээгээр 0.19 хувь болж өссөн ба 2015 онд хийсэн тандалтаар 0.98 хувийн халдварлалттай байв. Бид 2021- 2023 онуудад зорилтот санамсаргүй түүврийн арга ашиглан Монгол орны баруун, төв, зүүн бүсийг төлөөлсөн нийт 12 аймгийн 43 сумын 256 малчин өрхийн 2220, нийслэлийн Хан- Уул, Багануур, Налайх дүүргийн 47 өрхийн 600, нийт 2820 адууны адуунаас цусны ийлдсийн сорьц цуглуулсан.

Цуглуулсан ийлдсэнд Биокомбинат ТӨХХК-д үйлдвэрлэсэн Ямыг оношлох ХХУ-ын эсрэгтөрөгч ашиглан үйлдвэрлэгчийн зааврын дагуу урвал тавьж шинжилгээг гүйцэтгэв. Шинжилгээнд хамрагдсан нийт 2820 адууны 31 нь эерэг гарч 1.1%-ийн халдварлалттай байв. Энэхүү тандалтад хамрагдсан аймгуудын  $\frac{3}{4}$ -д, сумдын  $\frac{2}{3}$ , өрхийн 8%-д тус тус адууны ям оношлогдож байгаа нь анхаарал татаж, өвчин дахин сэргэж байгааг баталж байна.

**Түлхүүр үг:** *B. mallei*, ХХУ, ийлдэс судлалын тандалт

## **CAPSULE CURRICULUM VITAE**

**NAME:** B.Davaakhuu

**CURRENT AFFILIATION AND APPOINTMENT:**

Head of Airborne Infections Department, NCCD

**E-mail:** Ddavaa9970@gmail.com


**DEGREE:** MD, Clinical professor

**EMPLOYMENT:**

FROM: 2005 TO: Until now

EMPLOYER: NCCD

POSITION HELD: Head of Airborne Infections Department



**INTERESTED RESEARCH ARE:**

Chickenpox, Glander

## CLINICAL CASE OF GLANDER DISEASE IN MONGOLIA

B. Davaakhuu<sup>1</sup>, L. Orlomjav<sup>2</sup>, L. Purevsod<sup>1</sup>, B. Batsukh<sup>1</sup>, U. Unursaikhan<sup>2</sup>, Ts. Chinbayar<sup>1</sup>, B. Buyankhishig<sup>1</sup>, Ts. Bilegtsaikhan<sup>1</sup>, D. Bayarbold<sup>3</sup>

<sup>1</sup>National Center for Communicable Diseases,

<sup>2</sup>National Center for Zoonotic Disease

**Introduction:** Human Glanders are rare in the world, and one of the cases of human Glanders was diagnosed and treated in Mongolia in 2022. Delayed diagnosis and treatment of this disease have a high mortality rate (90-95 percent), and it is important to carefully study each clinical case and develop treatment and control guidelines.

**A clinical case:** The patient is 45 years old, male. Fever (39.7 degrees), severe headache, cough, runny nose, pain in the right leg. First, on 3.6.2022, he had a very severe headache and a lot of liquid nasal discharge, and at that time, he was called 103 and was injected with diclo-denc. As a result, he was shown to the Medical Center, Gyals Center, UHTE, and Military Central Hospital, and the diagnosis was not clear. In addition to the symptoms mentioned above when lying down, there was a 4x3 mass in the right leg's tibia section, heat to the touch in the front of the left thigh, without redness, and infiltration was palpable. In terms of epidemiology History, from 10.01.2020 to 01.20.2022, he worked at the National Institute of Veterinary Medicine in the laboratory on the study of samples of horse Glanders.

**Diagnosis:** Leukocytosis in CBC, ALT, and AST enzymes is 2–2.5 times higher in Biochemical tests. A chest X-ray revealed a homogenous infiltrative shadow in the lower area of the left lung with a poorly defined edge. A CT scan revealed a large mass and other small infiltrates in the right gluteal muscle and the left femur. An agglutination test revealed the pathogen in the blood. The specific gene of the causative agent of glanders was identified by PCR analysis in sputum. In the treatment, corticosteroids, liver protection, cardiovascular support, detoxification, rehydration, wound cleaning, and other anti-symptomatic treatments were used.

Cephalosporin group 3 antibiotics against the pathogen were combined with doxycycline and quinolones group drugs, but the fever continued and the infiltrates increased. , When cephalosporin group 4 antibiotics were treated together with quinolone group drugs, the temperature decreased from March 17-18, and the infiltration of the right leg decreased. As a result, the patient's condition improved during the treatment. On March 31, the right leg swelling was absorbed, and the left leg became painless, and other symptoms disappeared. On April 4, the patient's condition improved and he was discharged from the hospital.

**Conclusion:** This case of Glanders presented as a mixture of clinical skin and pulmonary manifestations. In addition, respiratory, cardiovascular, and liver complications occurred. However, due to the non-specificity of the symptoms, it is important to study more about this disease in order to prevent the death of gas without delaying the appropriate treatment.

## МОНГОЛД ТОХИОЛДСОН ЯМ ӨВЧНИЙ ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДЛЫН ТУХАЙ

Б. Даваахүү<sup>1</sup>, Л. Орломжав<sup>2</sup>, Л. Пүрэвсод<sup>1</sup>, Б. Батсүх<sup>1</sup>, У. Өнөрсайхан<sup>2</sup>, Ц.  
Чинбаяр<sup>1</sup>, Б. Буянхишиг<sup>1</sup>, Ц. Билэгтсайхан<sup>1</sup>, Д. Баярболд<sup>3</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup>Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв

<sup>3</sup>Эрүүл Мэндийн Яамны Нийтийн Эрүүл Мэндийн Газар

**Үндэслэл:** Дэлхий дахинд хүний ям өвчин нь ховор тохиолддог бөгөөд 2022 онд Монгол улсад хүний ям өвчний тохиолдол оношлогдож эмчлэгдсэн. Ям өвчний үед оношлогоо, эмчилгээ хоцорч нас барах явдал (90-95 хувь) өндөр байдаг бөгөөд эмнэлзүйн тохиолдол бүрийг нарийн судлаж эмчилгээний болон хяналтын удирдамж боловсруулах нь чухал байна.

**Эмнэлзүйн тохиолдол:** Өвчтөн 45 настай, эрэгтэй. Халуурна (39.7 хэм) толгой хүчтэй өвдөнө, ханиана, хамраас шингэн нус гарна, баруун хөл өвдөнө.

Анх 2022.3.6-нд толгой маш хүчтэй өвдөж, шингэн нус их гарч эхэлсэн бөгөөд тухайн үед 103 дуудан дикло-денк тариулсан. Улмаар цаашид МЯСЭ, Гялс төв, УХТЭ, Цэргийн төв эмнэлэг зэрэгт үзүүлэн онош тодрохгүй явсаар 2022.03.15-ны өдрөөс ХӨСҮТ-д хэвтэн эмчлүүлж эхэлсэн. Хэвтэх үед дээр дурьдсан шинжүүдээс гадна баруун хөлний шилбэ хэсэгт 4\*3 хэмжээтэй, зүүн гуяны урд хэсэгт хүрэхэд халуун, улаалтгүй, нэвчдэс тэмтрэгдсэн. Эпид анамнезийн хувьд 2022.01.10-01.20 хүртэл Мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторид Адууны ям өвчний дээж судалгаан дээр ажилласан.

**Оношилгоонд:** ЦЕШ-нд Лейкоцитоз, Биохимид АЛАТ, АСАТ фермент 2–2.5 дахин их. Цээжний рентген зурагт зүүн уушгины доод талбайд тодрол багатай зах ирмэг нь тод бус нэгэн төрлийн нэвчдэс сүүдэр илэрсэн. КТ шинжилгээнд баруун өгзөгний булчингийн харалдаа болон зүүн талын гуяны өмнөд хэсэгт томоохон хэмжээний мөн бусад жижиг хэмжээний нэвчдэс илэрсэн. Наалдуулах урвалын шинжилгээгээр цусанд ямын үүсгэгч эсрэг үүссэн



эсрэгбем илэрсэн. Цэрэнд PCR шинжилгээгээр ямын өвчин үүсгэгчийн өвөрмөц ген тодорхойлогдсон. Эмчилгээнд кортикостеройд, элэг хамгаалах, зүрх судас дэмжих, хордлого тайлах, шингэн сэлбэх, шархыг цэвэрлэх болон бусад шинж тэмдгийн эсрэг эмчилгээнүүдийг хэрэглэж эхэлсэн бөгөөд үүсгэгчийн эсрэг Цефалосфорины 3-р бүлгийн антибиотикийг доксицилин болон фоторхинолний бүлгийн эмтэй хавсран эмчилсэн боловч халууралт үргэлжлэж нэвчдэст голомтууд нэмэгдсэн тул Цефалосфорины 4-р бүлгийн антибиотикийг фоторхинолний бүлгийн эмтэй хавсарсан эмчлэхэд 3 сарын 17-18-наас эхлэн халуун буурч баруун хөлний нэвчдэс багассан. Улмаар эмчилгээнд өвчтөний биеийн байдал сайжирч, 3 сарын 31 нд баруун хөлний нэвчдэс шимэгдэж, зүүн хөлний нэвчдэс эмзэглэлгүй болж бусад шинж тэмдгүүд арилсан бөгөөд 4 сарын 4-ний өдөр өвчтөний биеийн байдал сайжирч, эдгэрч эмнэлгээс гарсан.

**Дүгнэлт:** Ям өвчний тус тохиолдол нь эмнэлзүйн арьсны болон уушгины холимог хэлбэрээр илэрсэн. Түүнчлэн амьсгал, зүрх судас, элэгний талаас хүндрэлүүд гарсан. Гэхдээ шинж тэмгүүдийн өвөрмөц бус байгаа байдлаас шалтгаалан энэ өвчний талаар илүү судлах нь зохих эмчилгээг цаг алдалгүй хийн нас баралтаас сэргийлэх чухал ач холбогдолтой байна.

